МЭДЭЭ · 2025 оны 4-р сарын 2

ХҮМҮҮЖЛИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ АВАГДСАН ХҮҮХДҮҮД БОЛОН АСРАН ХАМГААЛАГЧ НАРТАЙ НЬ УУЛЗАЖ, МЭДЭЭЛЭЛ ӨГЧЭЭ



Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас тус дүүргийн хэмжээнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдэд болон тэдний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт "Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хүүхдийн эрхийг хангах асуудал" сэдвийн хүрээнд сургалт, уулзалт зохион байгууллаа.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн, 18 насанд хүрээгүй хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр засан хүмүүжүүлэх зорилгоор шүүхээс хэрэглэж буй албадлагын арга хэмжээний нэг төрөл юм.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо бүрэн төлж, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй тохиолдолд шүүхээс тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсний дараа хугацаанаас нь чөлөөлөх хуулийн зохицуулалттай.

Сургалтаар албадлагын арга хэмжээнээс чөлөөлөгдөх үндэслэл, энэ арга хэмжээг

хэрхэн гүйцэтгэж, хяналт тавьдаг, албадлагын арга хэмжээг зөрчсөн тохиолдолд үүсэх үр дагаврыг тайлбарлаж, хууль, эрх зүйн зохицуулалтын талаар мэдээлэл өгчээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/723